



**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 6 сарын 13 өдөр

Дугаар А57

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, Монгол Банкны 2019 оны А-26 дугаар тушаалаар батлагдсан, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ын 11.4.3, Компанийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.4.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мэдээлэх үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Мөнгө угаах, болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий албан тушаалтнаар Төлбөр, тооцоо, эрсдэлийн удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн (М.Түмэнбуян) –г томилсугай.

3. М.Түмэнбуянгийн ажлын байрны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж батлуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэст даалгасугай.


4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/40 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн менежер (Б.Саруул)-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.НАРАНДЭЛГЭР



МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

1. ДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Хөдөө аж ахуйн бирж (“Бирж” гэх)-ийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг Монгол банкны Санхүүгийн мэдээллийн алба (цаашид “СМА” гэх)-д мэдээлэх болон энэхүү үйл ажиллагаатай холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмыг “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хууль, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны А/26 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам” болон эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон боловсруулав.
- 1.3. Энэхүү журмаар зохицуулаагүй харилцааг холбогдох хууль, дүрэм, журам, заавар зөвлөмж болон эрх зүйн бусад актыг баримтлан зохицуулна.

2. ДУГААР БҮЛЭГ. НЭР ТОМЬЁО

- 2.1. Энэхүү журамд дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1. “Сэжигтэй гүйлгээ” гэж мөнгөний гарал үүсэл, эцсийн хүлээн авагч нь тодорхой бус, эсхүл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн, түүнчлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзэж байгаа гүйлгээг;
 - 2.1.2. “Сэжигтэй гүйлгээний тайлан” гэж сэжигтэй гүйлгээ, түүнийг хийж гүйцэтгэсэн этгээдийн тухай мэдээллийг агуулсан Монгол банкнаас баталсан маягтын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс СМА-д хүргүүлэх баримт бичгийг;
 - 2.1.3. “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан нэр томьёоны тодорхойлолт дах үйл ажиллагааг;
 - 2.1.4. “Харилцагч” гэж “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “Биржийн арилжааны зах зээлд оролцогч” этгээд буюу Мэдээлэх үүрэгтэй этгээдээр үйлчлүүлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг;
 - 2.1.5. “Гүйлгээ” гэж “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4-т заасан буюу Худалдах, худалдан авах гэрээний дүнгийн дагуу худалдан авах гэрээний талуудын хооронд хийгдэх мөнгөн гүйлгээг;
 - 2.1.6. “Дэнчин, барьцаа хөрөнгийн гүйлгээ” гэж арилжаанд оролцогч биржийн

клирингийн дансанд баталгаа болгон байршуулсан дэнчин, барьцаа хөрөнгийг гэрээний үүргээ биелүүлсэн, биржид өр төлбөргүй тохиолдолд хүсэлтийн дагуу буцаан шилжүүлэх гүйлгээг;

2.1.7. “Гүйлгээг түдгэлзүүлэх” гэж сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг шалгах зорилгоор СМА-аас гаргасан шийдвэрийн дагуу тухайн гүйлгээг түр зогсоохыг;

2.1.8. “Харилцагчийн талаарх мэдээллийг шалгах” гэж харилцагчийг таньж мэдэх, харилцагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэх, зорилгоор харилцагчийн албан ёсны бичиг баримт (Иргэний үнэмлэх, гадаад паспорт гэх мэт)-ыг шалган үзэхийг;

2.1.9. “Харилцагчийн тухай албан ёсны бичиг баримт” гэж тухайн харилцагч хувь хүний овог, нэр, төрсөн эсхүл хуулийн этгээд бол байгуулагдсан он, сар, өдөр, баримтын дугаар бүхий төрийн байгууллагаас олгосон хугацаа нь хүчинтэй бичиг баримт (Иргэний үнэмлэх, гадаад паспорт, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ)-ын эх хувийг,

2.1.10. “Комплаенсын ажилтан” гэж Мэдээлэх үүрэгтэй этгээдийн томилсон хараат бус бие даасан ажилтан байх бөгөөд СМА-д сэжигтэй гүйлгээ, гүйлгээний талаарх мэдээллийг хүргүүлэх, хууль, журмын хэрэгжилтийг хангах, биелэлтэд хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий ажилтан;

3. ДУГААР БҮЛЭГ. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ

- 3.1. Компанийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийнэ. Эрсдэлийн үнэлгээг комплаенсын ажилтан хийж гүйцэтгэх ба эрсдэлийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:
 - 3.1.1. Харилцагчийн эрсдэл;
 - 3.1.2. Газар зүйн байршил болон бүс нутгийн эрсдэл;
 - 3.1.3. Бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл;
 - 3.1.4. Дансны төрөл эсхүл бизнесийн харилцааны зорилгоос үүсэх эрсдэл
 - 3.1.5. Гүйлгээтэй холбоотой эрсдэл (харилцагчийн гүйлгээний болон байршуулж байгаа хөрөнгийн хэмжээ, гүйлгээний давтамж болон санхүү, бизнесийн харилцаа тогтоосноос хойш өнгөрсөн хугацаа, гүйлгээний утга, хэмжээ хэвийн бусаар өөрчлөгдсөн эсхүл өндөр эрсдэлтэй улсаас хийгдсэн, дамжсан зэргийг анхаарна).
- 3.2. Харилцагчийн эрсдэлийн түвшинг үнэлж, өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг өндөр эрсдэлтэй харилцагчдад авч хэрэгжүүлэх.
- 3.3. Эрсдэлийн үнэлгээ болон түүнд ашигласан мэдээллийг баримтжуулан тухай бүр шинэчлэн хадгалах бөгөөд хянан шалгах эрх бүхий этгээд шаардсан үед гаргаж өгөхөд бэлэн байлгана.
- 3.4. Гүйцэтгэх захирал нь учирч болох мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний үр дүнд тулгуурлан тухайн эрсдэлийг удирдах, бууруулахад чиглэсэн оновчтой арга хэмжээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр, бодлого, журамд тусгана. Өндөр эрсдэлтэй тохиолдолд эрсдэлийг удирдах

- болон бууруулах нэмэлт арга хэмжээг авна.
- 3.5. Батлагдсан журмын дагуу сэжигтэй гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад гаргаж өгөх.
- 3.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хянах, мэдээлэх чиг үүрэг бүхий Компаенсын ажилтанг Гүйцэтгэх захирал томилно.

4. ДҮГЭЭР БҮЛЭГ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ

- 4.1. Компаенсын ажилтан нь дараах тохиолдолд харилцагчийн талаарх мэдээллийг шалгана. Үүнд:
- 4.1.1. Санхүүгийн харилцаа тогтоохын өмнө/биржийн гишүүнээр элсэх, арилжаанд орох, төлбөр тооцоо хийх гэх мэт/;
- 4.1.2. 20 сая төгрөг түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;
- 4.1.3. Богино хугацаанд хийж буй хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь 20 сая төгрөгөөс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бөгөөд СМА-нд мэдээлэх хэмжээнээс доогуур байлгах зорилгоор гүйлгээг хувааж хийж байна гэж үзэх үндэслэл байгаа бол;
- 4.1.4. Тухайн гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж үзэх үндэслэл байгаа бол;
- 4.2. Компаенсын ажилтан энэ журмын 4.1-т заасныг хэрэгжүүлэхдээ харилцагчаас дараах мэдээллийг гаргуулан авна. Үүнд:
- 4.2.1. Харилцагч нь иргэн бол түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, иргэний үнэмлэхнийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 4.2.2. Харилцагч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэр, албан ёсны хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, төлөөлөн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээдийн нэр, хаяг, хувь нийлүүлэгч, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга бүхий мэдээлэл бүхий хүчинтэй баримт бичиг эсвэл улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг;
- 4.2.3. Гүйлгээний утга, хүлээн авагчийн тухай мэдээлэл;
- 4.2.4. Бусдын өмнөөс гүйлгээ хийж байгаа тохиолдолд төлөөлүүлж байгаа этгээдийн талаарх мэдээлэл;
- 4.3. Харилцагчийн өгсөн мэдээлэл буруу, ташаа болох нь тогтоогдвол харилцагчаас энэ тухай тайлбар авах бөгөөд тайлбар өгөхөөс татгалзах, хуурамч мэдээлэл, үндэслэлгүй тайлбар өгсөөр байвал уг харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзана.

5. ДУГААР БҮЛЭГ. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ

- 5.1. Төлбөр тооцоо хариуцсан этгээд нь 20 сая төгрөг буюу түүнээс дээш хэмжээний мөнгөн гүйлгээг хийх бүрд гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан компаенсын ажилтанд мэдэгдэнэ.
- 5.2. Компаенсын ажилтан төлбөр тооцооны гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны баталсан маягтын дагуу

сэжигтэй гүйлгээний тайланг цахим хэлбэрээр эсхүл бичгээр нууцлал, аюулгүй байдлыг хангаж СМА-д хүргүүлнэ.

- 5.3. Мөнгөн дүнгээс нь үл хамааран аливаа гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэл байгаа бол уг гүйлгээг 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тайлангийн маягтын дагуу СМА-д мэдээлнэ.

6. ДУГААР БҮЛЭГ. ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ КОМПЛАЕНСЫН АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Комплаенсын ажилтан дараах эрх эдэлнэ.

6.1.1. Гүйлгээг түдгэлзүүлэх тухай СМА-ны даргын шийдвэрийг хүлээн авмагц нэн даруй хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

6.1.2. Шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлаа хангуулах талаар арга хэмжээ авхуулах;

6.1.3. Ажил үүргээ гүйцэтгэхэд саад болж байгаа асуудлаар удирдлагад санал гаргах, шаардлагатай бол СМА-д мэдээлэх.

- 6.2. Комплаенсын ажилтан дараах үүрэг хүлээнэ.

6.2.1. Комплаенсын ажилтан нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр боловсруулж, Гүйцэтгэх захирал, шаардлагатай тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, батлуулна

6.2.2. Төлбөр тооцоо болон сэжигтэй гүйлгээний тайлан, мэдээллийг СМА-д батлагдсан маягтын дагуу хуульд заасан хугацаанд хүргүүлэх;

6.2.3. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, хууль журмын хэрэгжилтийг хангуулах талаар сургалт зохион байгуулах;

6.2.4. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд хяналт тавьж, эрсдэлийн үнэлгээний аргаар өргөтгөсөн хяналт тавих;

6.2.5. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх тохиолдолд түүнийг мөнгө угаах зорилгод ашиглах эрсдэлийг судалж, санал дүгнэлтээ удирдлагад танилцуулан, шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авхуулах;

6.2.6. Харилцагчийн эрсдэлийн түвшинг байнга үнэлж, өндөр эрсдэл бүхий харилцагчийн гүйлгээ, дансанд хяналт тавьж ажиллах;

6.2.7. Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, СМА болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19.1 дэх хэсэгт заасан бусад эрх бүхий байгууллагаас баталсан заавар, зөвлөмжийг дагаж мөрдөнө.

- 6.2.8. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээллээр удирдлагыг хангах.

7. ДУГААР БҮЛЭГ. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- 7.1. Төлбөр тооцоо хариуцсан этгээд болон түүний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий этгээд нь харилцагчийн гүйлгээтэй холбоотой мэдээллийг СМА-д холбогдох хууль, журмын дагуу сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагааны талаар мэдээлсэн, нэмэлт мэдээлэл гаргаж өгсөн, мөнгө угаах болон терроризмыг

санхүүжүүлэх холбоотой шалгагдаж байгаа тухай аливаа хэлбэрээр харилцагчид өөрт нь болон бусад гуравдагч этгээдэд мэдээлэл дамжуулах, задруулах нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг зөрчсөн гэж үзэх үндэслэл болно. Энэ заалт нь Комплаенсын ажилтан, түүний удирдлага, болон ажилтан хоорондын харилцаа, хуульчид, эрх бүхий байгууллага, Прокурорын байгууллагад мэдээлэл дамжуулах болон солилцох, харилцаанд хамаарахгүй.

- 7.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу данс, гүйлгээг царцаах, сэжиглэхтэй холбоотой мэдээллийг эрх бүхий байгууллагын ажилтнаас бусад аливаа хувь хүн, хуулийн этгээдэд задруулж үл болно.
- 7.3. НҮБ-ын тогтоолоор террорист гэж зарлагдсан байгуулга, этгээд, улс орны нэрсийн жагсаалтад нэр нь орсон этгээдэд үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
- 7.4. Төлбөр тооцоо хариуцсан этгээд дотоод, гадаадын аливаа санхүүгийн байгууллагатай харилцаа тогтоохын өмнө бодитоор оршдог эсэхийг нь шалгах, зөвхөн интернэт, цахим хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай харилцаа тогтоохгүй байна.

8. ДУГААР БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА

- 8.1. Комплаенсын ажилтан, түүний удирдлага СМА болон эрх бүхий байгууллагад хууль, журамд заасны дагуу мэдээлэл өгснийг банкны, мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон хувь хүний нууцыг задруулсан гэж үзэхгүй.
- 8.2. Комплаенсын ажилтан, түүний удирдлагын өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй бодит хамааралтай эсэхээс үл хамааран Эрүүгийн, Иргэний болон Захиргааны хууль тогтоомжид заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.
- 8.3. СМА-д мэдээлбэл зохих гүйлгээний тайланг батлагдсан маягтын дагуу хугацаанд нь хүргүүлээгүй тохиолдолд мэдээлэх чиг үүрэг этгээд буюу Комплаенсын ажилтанд хариуцлага тооцох үндэслэл болно.
- 8.4. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд компанийн дотоод журам болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.